



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/15

Төмөрбулаг сум

Хариуцлагатай эргүүл жижүүр
томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сар шинийн баяр амралтын өдрүүдэд сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг ханган болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцлагатай эргүүл, жижүүрийн нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарийн дагуу хариуцлагатай эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэхдээ байгууллагуудын эргүүл жижүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллагын удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай эргүүл жижүүрүүдэд үүрэг болгосугай.

3. Баяр амралтын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийг сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд танилцуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан биелэлт үр дүнг 2024 оны 02 дүгээр сарын 13-ны өдөр танилцуулахыг Засаг даргын орлогч (Ч.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Г.БЯМБАСҮРЭН